



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/96/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мандалговь хот</p> <p>2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 40

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар залруулагдаагүй буюу хандив тусламжийн орлогыг Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан, төсвийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардалд зарцуулсан, нэмэгдлийг заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн олгосон зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2-т /Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, 25.7-д /Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана/ 60 дугаар зүйлийн 60.2-т /Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ/, 60.2.5-т /Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т /Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн

0012020763

хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/ заасныг тус тус зөрчсөн.

Запруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.6 дахин их, ангилал, эрх ба үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,562,236.96	89,675,749.64
33	АВЛАГА	11,356,896.49	25,929,991.49
335	Бусад авлага	11,356,896.49	25,929,991.49
3351	Байгууллагаас авах авлага	1,316,000.00	15,785,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,040,896.49	10,144,991.49
35	БАРАА МАТЕРИАЛ	134,205,340.47	63,745,758.15
351	Түүхий эд материал	16,410,250.00	16,214,415.00
35110	Тусгай зориулалттай материал	13,360,150.00	12,108,150.00
35130	Эм боох материал	3,050,100.00	4,106,265.00
354	Хангамжийн материал	49,574,090.47	47,531,343.15
35410	Бичиг хэргийн материал	1,859,824.80	1,147,315.00
35420	Аж ахуйн материал	43,034,122.67	43,219,100.15
35430	Сэлбэг хэрэгсэл	2,866,025.00	2,198,200.00
35450	Барилгын засварын материал	1,814,118.00	897,618.00
35460	Хүнсний материал	-	69,110.00
35600	Мал амьтад	68,221,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,880,650,991.15	6,215,245,448.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,880,650,991.15	6,215,245,448.86
392	Биет хөрөнгө	3,810,959,527.18	6,131,849,511.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,237,463,706.39	6,769,424,802.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(612,494,281.11)	(898,571,481.49)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138,958,130.00	107,008,130.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,601,150.37)	(44,799,030.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,258,350.20	144,263,933.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,141,808.53)	(47,329,845.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,024,990.60	69,171,007.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,018,492.68)	(18,121,253.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,565,000.00	53,535,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,054,917.32)	(2,731,750.68)
393	Биет бус хөрөнгө	69,691,463.97	83,395,937.74
39301	Програм хангамж	2,730,000.00	2,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,002,351.07)	(2,128,779.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	81,378,000.00	100,201,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(13,414,184.96)	(17,406,482.52)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,026,213,228.11	6,304,921,198.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	44,048.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	44,048.00
413	Өглөг	-	44,048.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	44,048.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,026,213,228.11	6,304,877,150.50
51	Засгийн газрын хувь оролцоо	4,026,213,228.11	6,304,877,150.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	479,936,623.37	479,936,623.37

51101	Өмч: - төрийн	479,936,623.37	479,936,623.37
512	Хуримтлагдсан үр дүн	2,755,951,576.95	5,034,657,533.99
51210	Өмнөх үеийн үр дүн	2,755,951,576.95	2,755,993,611.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,278,663,922.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,325,027.79	790,282,993.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,026,213,228.11	6,304,921,198.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	606,064,956.00	3,218,597,710.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,243,646.00	2,724,818,260.61
120	Нийтлэг татварын бус орлого	141,243,646.00	2,724,818,260.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	141,243,646.00	2,724,818,260.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,001.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,243,645.00	2,724,818,260.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,821,310.00	493,779,449.83
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,853,510.00	89,399,749.83
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,200,000.00	15,659,187.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,540,434.00	41,392,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,113,076.00	32,347,972.83
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	405,967,800.00	404,379,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	405,967,800.00	404,379,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	698,758,484.66	939,818,651.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,691,817.66	939,818,651.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,154,427.22	904,564,682.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,745,689.00	249,388,203.98
210101	Үндсэн цалин	148,327,400.00	149,925,000.98
210102	Нэмэгдэл	60,503,352.00	51,350,082.00
210104	Урамшуулал	-	10,012,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,914,937.00	38,100,521.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,228,268.68	32,465,746.60
210201	Тэтгэврийн даатгал	19,002,757.63	22,766,155.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,236,369.56	2,532,182.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,788,875.68	2,025,744.70
210204	Ажилгүйдлийн даатгал	374,337.90	466,974.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,825,927.91	4,674,689.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,941,597.83	40,364,147.62
210301	Гэрэл, цахилгаан	3,667,308.83	5,150,722.62
210302	Түлш, халаалт	18,768,161.00	32,720,625.00
210303	Цэвэр, бохир ус	4,506,128.00	2,492,800.00

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	18,954,070.80	93,541,277.74
210401	Бичиг хэрэг	2,111,720.80	3,721,131.80
210402	Тээвэр, шатахуун	12,968,900.00	10,901,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,945,450.00	2,475,923.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	928,000.00	2,175,041.20
210408	Бараа материал акталсны зардал	-	25,197,931.32
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	49,070,000.00
2105	Нормативт зардал	52,500.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,373,200.00	10,391,325.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	601,000.00	-
210604	Урсгал засвар	3,772,200.00	10,391,325.00
2107	Томилолт, зочны зардал	5,992,000.00	3,350,000.00
210702	Дотоод албан томилолт	5,992,000.00	3,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,265,245.05	18,407,004.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,569,674.05	16,485,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	81,676.00	398,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,275.00	119,374.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	730,000.00	1,175,000.00
210807	Газрын төлбөр	207,620.00	207,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,601,855.86	456,656,976.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,083,030.00	81,558,176.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	610,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	330,798,825.86	374,488,800.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,537,390.44	35,253,968.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,004,900.00	8,933,728.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,070,128.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,004,900.00	4,863,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,532,490.44	26,320,240.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,532,490.44	26,320,240.41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,667.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	66,667.00	-
223001	Бусад хөрөнгө	66,667.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(92,693,528.66)	2,278,779,059.34
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	166,666.80
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	166,666.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,259,615.95	281,803.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	27,259,615.95	281,803.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(27,259,615.95)	(115,136.95)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(119,953,144.61)	2,278,663,922.39

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	479,936,623.37	801,639,597.29	2,864,590,152.06	4,146,166,372.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	11,314,569.50	11,314,569.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	479,936,623.37	801,639,597.29	2,875,904,721.56	4,157,480,942.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-11,314,569.50	0.00	-11,314,569.50
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-119,953,144.61	-119,953,144.61
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,325,027.79	2,755,951,576.95	4,026,213,228.11
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,325,027.79	2,755,951,576.95	4,026,213,228.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	479,936,623.37	790,325,027.79	2,755,951,576.95	4,026,213,228.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	42,034.65	42,034.65
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	479,936,623.37	790,325,027.79	2,755,993,611.60	4,026,255,262.76
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	-42,034.65	0.00	-42,034.65
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	959,873,246.74	1,580,608,020.93	5,511,987,223.20	8,052,468,490.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>467,218,011.00</u>	<u>496,914,354.83</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1.00	238,905.00

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	1.00	238,905.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1.00	238,905.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1.00	238,905.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,218,010.00	496,675,449.83
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,250,210.00	92,295,749.83
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,200,000.00	15,659,187.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,540,434.00	41,392,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,509,776.00	35,243,972.83
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	405,967,800.00	404,379,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	405,967,800.00	404,379,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	378,298,011.00	463,997,854.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,298,011.00	463,997,854.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,760,620.56	428,743,886.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,745,689.00	249,383,655.98
210101	Үндсэн цалин	148,327,400.00	149,920,452.98
210102	Нэмэгдэл	60,503,352.00	51,350,082.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	-	10,012,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,914,937.00	38,100,521.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,228,268.68	32,465,746.60
210201	Тэтгэврийн даатгал	19,002,757.63	22,766,155.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,236,369.56	2,532,182.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,788,875.68	2,025,744.70
210204	Ажилгүйдлийн даатгал	374,337.90	466,974.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,825,927.91	4,674,689.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,941,597.83	40,364,147.62
210301	Гэрэл, цахилгаан	3,667,308.83	5,150,722.62
210302	Түлш, халаалт	18,768,161.00	32,720,625.00
210303	Цэвэр, бохир ус	4,506,128.00	2,492,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,977,440.00	22,641,995.42
210401	Бичиг хэрэг	3,148,090.00	3,297,122.00
210402	Тээвэр, шатахуун	12,968,900.00	10,901,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,945,450.00	2,475,923.42
210404	Ном, хэвлэл	50,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,817,000.00	5,967,700.00
2105	Нормативт зардал	610,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	610,000.00	1,000,000.00

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,216,600.00	22,772,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга	-	14,469,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,489,100.00	-
210604	Урсгал засвар	3,727,500.00	8,303,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,992,000.00	3,350,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	5,992,000.00	3,350,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,941,245.05	18,407,004.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,885,674.05	16,485,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	81,676.00	398,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,275.00	119,374.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,090,000.00	1,175,000.00
210807	Газрын төлбөр	207,620.00	207,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,107,780.00	38,359,336.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,387,780.00	37,749,336.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	610,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,537,390.44	35,253,968.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,004,900.00	8,933,728.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,070,128.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,004,900.00	4,863,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,532,490.44	26,320,240.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,532,490.44	26,320,240.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>88,920,000.00</u>	<u>32,916,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	88,920,000.00	32,916,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,920,000.00	32,916,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	88,920,000.00	32,916,500.00
223001	Бусад хөрөнгө	21,565,080.00	10,136,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	67,354,920.00	22,780,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(88,920,000.00)</u>	<u>(32,916,500.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	404,379,700.00	401,091,486.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,243,200.00	390,954,986.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,743,200.00	385,474,857.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,065,000.00	239,371,055.98
210101	Үндсэн цалин	149,954,400.00	149,920,452.98
210102	Нэмэгдэл	51,496,200.00	51,350,082.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,614,400.00	38,100,521.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,869,300.00	31,180,275.60
210201	Тэтгэврийн даатгал	22,038,800.00	21,792,708.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,461,500.00	2,423,156.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,980,100.00	1,938,523.90
210204	Ажилгүйдлийн даатгал	513,700.00	456,449.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,875,200.00	4,569,437.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,889,700.00	37,870,626.21
210301	Гэрэл, цахилгаан	2,663,700.00	2,657,201.21
210302	Түлш, халаалт	32,726,000.00	32,720,625.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,492,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,089,600.00	16,938,695.42
210401	Бичиг хэрэг	2,572,000.00	2,567,022.00
210402	Тээвэр, шатахуун	6,811,500.00	6,670,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,306,100.00	2,300,923.42
210404	Ном, хэвлэл	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.00	5,400,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,986,600.00	40,906,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,279,600.00	20,200,000.00
210602	Тавилга	17,050,000.00	17,049,000.00
210604	Урсгал засвар	3,657,000.00	3,657,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,500,000.00	3,350,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	3,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,592,000.00	3,122,004.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300,000.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	398,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	119,374.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,332,000.00	1,175,000.00
210807	Газрын төлбөр	210,000.00	207,620.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,751,000.00	11,736,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,137,000.00	11,126,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	614,000.00	610,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,500,000.00	5,480,128.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,500,000.00	5,480,128.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,070,200.00	4,070,128.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,429,800.00	1,410,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,136,500.00	10,136,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,136,500.00	10,136,500.00
223001	Бусад хөрөнгө	10,136,500.00	10,136,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	404,379,700.00	401,091,486.01
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	404,379,700.00	401,091,486.01
122005	Орон нутгийн төсвөөс	404,379,700.00	401,091,486.01
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22.00	25.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	24.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	2.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,295,749.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,049,028.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,049,028.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,012,600.00
210104	Урамшуулал	10,012,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,285,471.00
210201	Тэтгэврийн даатгал	973,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	109,026.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	87,220.80
210204	Ажилгүйдлийн даатгал	10,525.20
210205	Эрүүл мэндийн даатгал	105,252.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,493,521.41
210301	Гэрэл, цахилгаан	2,493,521.41
2104	Хангамж, бараа материалын зардал	5,703,300.00
210401	Бичиг хэрэг	730,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,230,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	567,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,646,000.00
210604	Урсгал засвар	4,646,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,285,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,285,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,623,136.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,623,136.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,453,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,453,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,453,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,793,121.42
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	22,793,121.42
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,295,749.83
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,295,749.83
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,659,187.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,392,590.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,243,972.83
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж, тасралтгүй суралцагч алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүү, төрийн сангийн дотоод хяналтаас 2020 он, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийсэн байна. Хяналт, шалгалтын дүнд 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 939,818.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,398.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,578.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,278,708.0 мянган төгрөгөөр буюу 56.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	11,356.9	25,930.0	14,573.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	134,205.3	63,745.8	-70,459.6
Үндсэн хөрөнгө	3,880,651.0	6,215,245.4	2,334,594.5
Нийт хөрөнгө	4,026,213.2	6,304,921.2	2,278,708.0
Өр төлбөр	-	44.0	44.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,026,213.2	6,304,877.2	2,278,663.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,026,213.2	6,304,921.2	2,278,708.00

Эргэлтийн хөрөнгийн дүн 89,675.8 сая төгрөг болж өмнөх оноос 55,886.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 49,070.0 мянган төгрөгийн төмөр сүргийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, 25,197.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассантай холбоотой байна.

Мөн авлагын данс өмнөх оноос 14.6 сая төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага буюу тавилга худалдан авч, биетээр хүлээн аваагүйтэй холбоотой нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,215,245.4 мянган төгрөг болж, 2,334,594.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ЗДТГ-ын барилгыг орлого авч тайлагнасангай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,304,877.2 мянган төгрөг болж 2,278,663.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 363,921.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 363,921.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 40,458.0 мянган төгрөгөөр бууруулан 404,379.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 404,379.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 404,379.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.2 хувийг зарцуулж, 3,288.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401,091.5 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, дотоод албан томилолтын зардлын гүйцэтгэл дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 41,392.6 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 15,659.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн болон нэмэлт үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35,244.0 мянган төгрөг, нийт 92,295.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 10,012.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,285.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 2,493.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5,703.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4,646.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 15,285.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,623.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 3,453.6 мянган төгрөг, нийт 69,502.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 22,793.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м³ тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 34,390.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул гэрээний үнэ 32,720.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,139,470.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй оффисын барилгыг 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 86 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн дансанд орлого авч, бүртгэл тайланд тусгасан байна.
3. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Эко глабал ложистикс” ХХК-аас сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор 10,000.0 мянган төгрөгийг хандивласан байна. Тус хандивыг Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-гийн дансанд төвлөрүүлэн сумын хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтад зарцуулах байсан боловч нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.
4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас байгалийн гамшигт үзэгдэл болон ковид цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан 15,659.2 мянган төгрөгийн хандивыг өгсөн байна. Хандивыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй буюу хандив, тусламжийн орлогыг ОНХС-гийн дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан, төсвийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардалд зарцуулсан,

нэмэгдлийг заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн олгосон зэрэг зөрчил илэрсэн нь аудитын гол асуудал байна гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 555,391.2 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол зөрчсөн зөрчлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1,684.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. Төлбөрийн актыг барагдуулсан, албан шаардлын дагуу 7,545.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд холбогдох материалуудыг, авлагатай иргэдэд авлага барагдуулах тухай мэдэгдэх хуудсыг тус тус хүргүүлсэн боловч авлага төлөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого, шатахууны давтан тооцооллыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 112,687.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс:

Завсрын аудитаар 73,221.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,537.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,974.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн;

Жилийн эцсийн аудитаар 1,500.0 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 29,755.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 68,221.0 мянган төгрөгийн төмөр сүргийг бараа материалаар бүртгэсэн;
2. Дутагдсан 5,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай ИТХ-ын шийдвэр гараагүй байхад нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж, туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн;

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 73,221.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт,

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнд 1,500.0 мянган төгрөгийг бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг нөхөн төлүүлэхээр 1,500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдэд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагуудыг хүргүүлээ. Үүнд:

1. Бэлтгэн нийлүүлэгчид тоног төхөөрөмжийн үнийг 2020 оны 11 дүгээр сард шилжүүлж, хөрөнгийг биетээр хүлээн аваагүй байхад орлого авч тайланд тусгасан;
2. Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг 2019 оноос хойш шинэчлэн гаргаагүй, ажилтан албан хаагчидтай бүрэн хариуцлагын гэрээг байгуулаагүй;
3. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 5,537.0 мянган төгрөгийг төсвийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан;
4. Төсвийн хөрөнгөөр 17,049.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн;
5. Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг 2,706.3 мянган төгрөгөөр илүү олгосон;
6. Аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн 10,000.0 мянган төгрөгийн хандивыг ОНХС-гийн дансанд төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Нийт 35,292.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Зөвлөмж

Завсрын аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүллээ. Үүнд:

1. Тули халаалтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- 1 Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагатай халаалтын гэрээг байгуулахдаа батлагдсан төсвөөс 2,974.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн байгуулсан.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд харилцагч байгууллагатай гэрээ, хэлэлцээрийг байгуулж, зарцуулалтад нь хяналт тавих.

Дээрх зөвлөмжийг завсрын аудитаар хүргүүлж, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/64 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д / д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг 2019 оноос хойш шинэчлэн гаргаагүй, ажилтан албан хаагчидтай бүрэн хариуцлагын гэрээг байгуулаагүй.	1	-					1	-		
2	Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагатай халаалтын гэрээг байгуулахдаа батлагдсан төсвөөс хэтрүүлэн байгуулсан.	1	2,974.6							1	2,974.6
3	Төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	1	17,049.0					1	17,049.0		
	Дүн	3	20,023.6					2	17,049.0	1	2,974.6
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Бэлтгэн нийлүүлэгчид тоног төхөөрөмжийн үнийг 2020 оны 11 дүгээр сард шилжүүлж,	1	-					1	-		

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	хөрөнгийг биетээр хүлээн аваагүй байхад орлого авч тайланд тусгасан.										
2	Төмөр сүргийг бараа материалаар бүртгэсэн	1	68,221.0	1	68,221.0						
3	Дутагдсан үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай ИТХ-ын шийдвэр гараагүй байхад нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж, туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	1	5,000.0	1	5,000.0						
4	Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан.	1	5,537.0					1	5,537.0		
5	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг илүү олгосон	1	2,706.3					1	2,706.3		
6	Аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивыг ОНХС-гийн дансанд төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар зарцуулсан.	1	10,000.0					1	10,000.0		
7	Төсвийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнд бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.	1	1,500.0			1	1,500.0				
	Нийт зөрчлийн дүн	10	112,987.9	2	73,221.0	1	1,500.0	6	35,292.3	1	2,974.6